



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд Дулааны станц ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/02/НА-СТА-ОНА

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Ховд хот

2023 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Аудитор: Д.Балжинням

Утас: 99435309

цахим хаяг: D.Baljinnyam@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....</b>	<b>3</b>
<b>Асуудлыг онцолсон хэсэг .....</b>	<b>3</b>
<b>Аудитын гол асуудал .....</b>	<b>3</b>
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....</b>	<b>5</b>
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....</b>	<b>10</b>
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН .....</b>	<b>14</b>
<b>4.1 Ерөнхий зүйл .....</b>	<b>14</b>
<b>4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....</b>	<b>14</b>
<b>4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....</b>	<b>14</b>
<b>4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....</b>	<b>14</b>
<b>4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....</b>	<b>16</b>
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....</b>	<b>17</b>
<b>5.1 Залруулсан алдаа .....</b>	<b>17</b>
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....</b>	<b>18</b>

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТУЗ	Төлөөлөн Удирдах зөвлөл
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
НӨАТ	Нэмүү өртгийн албан татвар
БМ	Бараа материал
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ДҮТ	Диспетчерийн үндэсний төв

### **Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Ховд дулааны станц” ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ховд дулааны станц” ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### **Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### **Асуудлыг онцолсон хэсэг**

Монгол Улсын Их хурлын тогтоолоор дулааны хэрэглээний өсөлтийг хангах зорилгоор тус станцын одоо ажиллаж байгаа хүчин чадлыг нэмэгдүүлэх эх үүсвэрийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022- 2023 онуудад 8000.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил тусгагдсаны дагуу гүйцэтгэгч шалгарч барилгын ажил эхэлсэн байна.

### **Аудитын гол асуудал**

Эрчим хүчний сайдын 2022 оны А/135 дугаар тушаалаар 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд нийт орлогыг 3982.4 сая төгрөгөөр, нийт зардлыг 4936.2 сая төгрөгөөр, алдагдлыг 953.9 сая төгрөг байхаар баталсан байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 17 дугаар тогтоолоор орлогыг нэмэгдүүлээгүй, үндсэн түүхий эд материал болох шатахуун, сэлбэг хэрэгсэл, тээврийн хөлс нэмэгдсэн зэргээс шалтгаалан нийт 5078.1 сая төгрөгөөр, алдагдлыг 1095.7 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн тодотгосон байна.

Гүйцэтгэлээр 4712.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 4723.9 сая төгрөгийн зардал гарган, 11.7 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Компанийн 2022 оны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 133 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийг 90.4 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн хүлээх үүрэг, хариуцлага**

Компанийн удирдлага санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Х.БОЛДБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,653,806,051.95</u></b>	<b><u>1,497,066,665.38</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	2,532,391.95	14,625,629.17
<b>311</b>	<b>Кассанд байгаа бэлэн мөнгө</b>	84,852.00	473,218.16
31110	Төгрөг	84,852.00	473,218.16
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	2,447,539.95	14,152,411.01
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	2,447,539.95	14,152,411.01
31213	Арилжааны банк дахь харилцах	2,447,539.95	14,152,411.01
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	731,180,570.30	594,433,322.57
33401	Дансны авлага /ТӨҮГ/	703,761,833.92	569,636,197.13
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	27,418,736.38	21,855,898.18
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	-	2,941,227.26
3351	Байгууллагаас авах авлага		2,941,227.26
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	-	21,345,000.00
<b>3471</b>	<b>Урьдчилгаа тооцоо</b>	-	21,345,000.00
34711	Бараа материал бэлтгэх урьдчилгаа		20,000,000.00
34712	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа		1,345,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	920,093,089.70	866,662,713.64
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	399,577,152.57	334,974,807.08
35300	Бэлэн бүтээгдэхүүн	47,720,000.01	11,922,727.28
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	472,795,937.12	519,765,179.28
35410	Бичиг хэргийн материал	6,438,518.27	4,719,454.79
35420	Аж ахуйн материал	10,115,600.12	9,343,901.06
35430	Сэлбэг хэрэгсэл	440,651,963.12	491,016,932.56
35460	Хүнсний материал	6,363.64	172,550.91
35470	Бусад хангамжийн материал	15,583,491.97	14,512,339.96
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>11,049,312,437.69</u></b>	<b><u>11,625,130,767.65</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	11,049,312,437.69	11,625,130,767.65
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	10,843,206,437.85	10,892,294,100.75
39201	Барилга, байгууламж, орон сууц	7,872,111,308.98	7,892,874,272.62
39202	Хуримтлагдсан элэгдэл	(740,296,512.80)	(990,882,433.24)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	126,468,181.82	190,104,545.46
39204	Хуримтлагдсан элэгдэл	(80,922,727.33)	(92,416,161.68)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	7,825,440,685.51	8,513,576,530.06
39206	Хуримтлагдсан элэгдэл	(4,174,659,882.36)	(4,640,240,603.86)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	35,433,281.82	43,853,281.82
39208	Хуримтлагдсан элэгдэл	(20,367,897.79)	(24,575,330.43)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	206,105,999.84	732,836,666.90
39301	Програм хангамж	20,910,000.00	20,910,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(16,954,000.16)	(20,909,999.80)
39303	Техник эдийн засгийн үндэслэл		44,900,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл		(7,483,333.30)
39305	Бусад биет бус хөрөнгө	202,150,000.00	695,420,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>12,703,118,489.64</u></b>	<b><u>13,122,197,433.03</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>1,097,808,130.68</u></b>	<b><u>1,116,799,773.59</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	1,097,808,130.68	1,116,799,773.59
<b>412</b>	<b>Богино хугацаат зээлийн өглөг</b>	-	80,000,000.00

<b>4121</b>	<b>Төгрөг</b>	-	80,000,000.00
41214	Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн зээл	-	80,000,000.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	1,088,419,868.74	1,006,570,801.09
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	1,088,375,308.15	1,006,570,801.09
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	94,672,453.76	205,445,071.92
41365	Ноогдол ашгийн өглөг /ТӨҮГ/		60,000,000.00
41366	Дансны өглөг /ТӨҮГ/	993,702,854.39	741,125,729.17
<b>414</b>	<b>Урьдчилж орсон орлого</b>	9,388,261.94	30,228,972.50
41440	Бусад урьдчилж орсон орлого	9,388,261.94	6,228,972.50
41450	Төрийн өмчийн үйлдвэр, аж ахуйн газар		24,000,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>11,442,464,205.25</b>	<b>12,005,397,659.44</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	11,442,464,205.25	12,005,397,659.44
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	13,842,676,161.23	14,335,946,161.23
51101	Өмч: - төрийн	13,285,935,498.23	13,640,526,161.23
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	556,740,663.00	695,420,000.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(3,557,183,357.80)	(3,487,519,903.61)
51210	Өмнөх үеийн үр дүн	(3,557,183,357.80)	(3,475,737,204.09)
51220	Тайлант үеийн үр дүн		(11,782,699.52)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,156,971,401.82	1,156,971,401.82
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>12,540,272,335.93</b>	<b>13,122,197,433.03</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Мөрийн дугаар	Балансын зүйл	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
01	Борлуулалтын орлого (цэвэр)	3,584,347,210.23	4,015,298,487.62
02	Борлуулалтын өртөг	2,935,859,500.77	3,811,174,671.15
03	Нийт ашиг( алдагдал)	648,487,709.46	204,123,816.47
08	Бусад орлого	239,333,741.90	696,893,963.69
08.1	Орлогын дүн	239,333,741.90	696,893,963.69
09	Борлуулалт, маркетингийн зардал	103,597,226.09	138,012,928.45
10	Ерөнхий ба удирдлагын зардал	621,378,071.56	726,989,635.09
12	Бусад зардал	0.00	47,797,916.14
12.1	Зардлын дүн	724,975,297.65	912,800,479.68
18	Татвар төлөхийн өмнөх ашиг( алдагдал)	162,846,153.71	-11,782,699.52
20	Татварын дараах ашиг (алдагдал)	162,846,153.71	-11,782,699.52
22	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)	162,846,153.71	-11,782,699.52

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>4,119,877,958.09</u></b>	<b><u>5,287,823,913.05</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>4,119,877,958.09</b>	<b>4,937,823,913.05</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	4,119,877,958.09	4,737,823,913.05
120009	Бусад орлого	68,551,286.00	203,665,547.00
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	4,047,577,206.09	4,532,504,656.05
120015	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө /ТӨҮГ/	3,749,466.00	1,653,710.00
<b>123</b>	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	-	200,000,000.00
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого		200,000,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	-	<b>350,000,000.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	-	350,000,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		350,000,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>3,756,429,073.83</u></b>	<b><u>4,611,051,926.83</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,756,429,073.83</b>	<b>4,611,051,926.83</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,756,429,073.83</b>	<b>4,611,051,926.83</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	977,836,340.12	1,360,395,036.99
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	977,836,340.12	1,360,395,036.99
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	330,733,924.37	439,553,257.26
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	330,733,924.37	439,553,257.26
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	526,352,777.00	967,115,585.72
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	526,352,777.00	967,115,585.72
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1,487,589,983.72	1,538,281,141.58
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	775,547,395.72	729,795,949.58
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	712,042,588.00	808,485,192.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	433,916,048.62	305,706,905.28
210815	Хүүний төлбөрт төлсөн /ТӨҮГ/	4,656,683.31	
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	424,695,032.47	279,276,923.78
210817	Даатгалын төлбөрт төлсөн /ТӨҮГ/	897,325.00	1,917,800.00
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	3,667,007.84	24,512,181.50
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>363,448,884.26</u></b>	<b><u>676,771,986.22</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>199,355,900.00</b>	<b>723,278,749.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>199,355,900.00</b>	<b>723,278,749.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>199,355,900.00</b>	<b>723,278,749.00</b>

225101	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	199,355,900.00	723,278,749.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(199,355,900.00)</u></b>	<b><u>(723,278,749.00)</u></b>
14	<b>Бусад эх үүсвэр</b>	-	342,300,000.00
145007	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		342,300,000.00
25	<b>Санхүүгийн үйл ажиллагааны зардал</b>	165,069,124.52	283,700,000.00
250002	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	165,069,124.52	262,300,000.00
250005	Төлсөн ногдол ашиг		21,400,000.00
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b><u>(165,069,124.52)</u></b>	<b><u>58,600,000.00</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	(976,140.26)	12,093,237.22
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	3,508,532.21	2,532,391.95
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	2,532,391.95	14,625,629.17

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	13,488,085,498.23	1,156,971,401.82	- 3,557,183,357.82	11,087,873,542.23
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	13,488,085,498.23	1,156,971,401.82	- 3,557,183,357.80	11,087,873,542.25
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	354,590,663.00	0.00	0.00	354,590,663.00
C07	Тайлант үеийн үр дүн			162,846,153.71	162,846,153.71
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	13,842,676,161.23	1,156,971,401.82	- 3,394,337,204.09	11,605,310,358.96
D01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	14,197,266,824.23	1,156,971,401.82	- 3,231,491,050.38	11,605,310,358.96
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	13,842,676,161.23	1,156,971,401.82	- 3,394,337,204.09	11,605,310,358.96
D07	Өмчид гарсан өөрчилөлт	493,270,000.00			493,270,000.00

D08	Зарласан ногдол ашиг				-81,400,000.00	-81,400,000.00
D10	Тайлант үеийн үр дүн				-11,782,699.52	-11,782,699.52
D011	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>14,335,946,161.23</b>	<b>1,156,971,401.82</b>	<b>-</b>	<b>3,487,519,903.61</b>	<b>12,005,397,659.44</b>

## 2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлтүүд	Хэмжик нэгж	2021 оны гүйцэтгэл	2022 он		Харьцуулалт өссөн/+, буурсан/-			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2021 оны гүйцэтгэлтэй		Төлөвлөгөөтэй	
						Тоо	хувь	Тоо	хувь
1	Үйлдвэрлэсэн ДЭХ	Гкал	<b>63,506.4</b>	65,767.8	<b>74,532.2</b>	11,025.8	17.4	8,764.4	13.3
1	Дотоод хэрэгцээний дулааны эрчим хүч	Гкал	1,166.6	1,123.2	1,003.7	- 162.9	- 14.0	- 119.5	- 10.6
		хувь	1.8	1.7	1.3	- 0.5	- 26.7	- 0.4	- 21.1
1	Түгээсэн ДЭХ	Гкал	<b>62,339.8</b>	64,644.6	<b>73,528.5</b>	11,188.7	17.9	8,883.9	13.7
1	Шугамын алдагдал	Гкал	14,137.5	9,716.1	19,221.5	5,084.1	36.0	9,505.4	97.8
2	Борлуулсан ДЭХ	Гкал	<b>48,202.4</b>	54,928.5	<b>54,307.0</b>	6,104.6	12.7	- 621.5	- 1.1
2	<b>Нийт орлого</b>	<b>сая.төг</b>	<b>3,823.7</b>	<b>3,982.4</b>	<b>4,712.2</b>	<b>888.5</b>	<b>23.2</b>	<b>729.8</b>	<b>18.3</b>
	<b>Үүнээс:Борлуулалтын орлого</b>	<b>сая.төг</b>	<b>3,584.3</b>	<b>3,482.4</b>	<b>4,015.3</b>	<b>431.0</b>	<b>12.0</b>	<b>532.9</b>	<b>15.3</b>
	<b>Үйл ажиллагааны бусад орлого</b>	<b>сая.төг</b>	<b>239.3</b>	<b>181.8</b>	<b>378.7</b>	<b>139.4</b>	<b>58.2</b>	<b>196.9</b>	<b>108.3</b>
	<b>Санхүүжилт (татаас)</b>	<b>сая.төг</b>	<b>-</b>	<b>318.2</b>	<b>318.2</b>	<b>318.2</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
3	<b>Нийт зардал</b>	<b>сая.төг</b>	<b>3,660.8</b>	<b>5,078.1</b>	<b>4,723.98</b>	<b>1,063.1</b>	<b>29.0</b>	<b>- 354.1</b>	<b>- 7.0</b>
	<b>Үүнээс:Үйл ажиллагааны зардал</b>	<b>сая.төг</b>	<b>3,660.8</b>	<b>5,078.1</b>	<b>4,676.2</b>	<b>1,015.3</b>	<b>27.7</b>	<b>- 401.9</b>	<b>- 7.9</b>
	<b>Үйл ажиллагааны бус зардал</b>	<b>сая.төг</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>47.8</b>	<b>47.8</b>	<b>-</b>	<b>47.8</b>	<b>-</b>
4	<b>Татварын өмнөх ашиг /алдагдал/</b>	<b>сая.төг</b>	162.8	-1,095.7	- 11.78	- 174.6	- 107.2	1,083.9	- 98.9
5	<b>Цэвэр ашиг, алдагдал</b>	<b>сая.төг</b>	162.8	-1,095.7	- 11.8	- 174.6	- 107.2	1,083.9	- 98.9
6	<b>Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал</b>	<b>төгрөг</b>	1.0	<b>1.28</b>	1.00	0.0	4.7	- 0.27	- 21.4
7	<b>Нийт авлага</b>	<b>сая.төг</b>	731.2	211.1	615.8	- 115.4	- 15.8	404.7	191.8
	<b>Үүнээс: ЭХ-ний авлага</b>	<b>сая.төг</b>	691.5	211.1	519.8	- 171.7	- 24.8	308.7	146.3
	<b>Бусад авлага</b>	<b>сая.төг</b>	39.7	-	96.0	56.3	141.7	96.0	
8	<b>Нийт өр төлбөр</b>	<b>сая.төг</b>	1,097.8	779.0	1,116.8	19.0	1.7	337.8	43.4
	<b>Үүнээс: Богино хугацаат</b>	<b>сая.төг</b>	1,097.8	779.0	1,116.8	19.0	1.7	337.8	43.4
	<b>Урт хугацаат өр төлбөр</b>	<b>сая.төг</b>	-	-	-	-	-	-	-
9	<b>Хөрөнгө оруулалт их засвар ТЗБАХ</b>	<b>сая.төг</b>	375.8	<b>821.74</b>	791.8	416.0	110.7	- 30.0	- 3.6
10	<b>Жишмэл түлшний хувийн зарцуулалт ДЭХ</b>	<b>кг.гкал</b>	262.9	<b>277.4</b>	272.0	9.1	3.5	- 5.4	- 1.9
11	<b>Нийт ажиллагсдын тоо</b>	<b>хүн</b>	107.0	108.0	107.0	-	-	- 1.0	- 0.9
12	<b>Нийт цалингийн сан</b>	<b>сая.төг</b>	1,118.6	1,791.0	1,600.1	481.6	43.1	- 190.9	- 10.7

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

---

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Компанийн техник эдийн засгийн үзүүлэлтийг дээшлүүлэх, түлш эрчим хүчний нөөцийг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулан дулааны эрчим хүчээр нийт хэрэглэгчдийг найдвартай хангах, байгаль орчинд үзүүлэх хор хөнөөлийг бууруулах, “Ногоон үйлдвэрлэлийг хөгжүүлэх” эрхэм зорилт дэвшүүлж, зуухныхаа хийцийг боловсронгуй болгох, ашигт үйлийн коэффициентийг нэмэгдүүлэх, станц, дэд станцын хүчин чадлыг өргөтгөх, цаашдаа өсөн нэмэгдэж байгаа дулааны хэрэглээг хангах зэрэг мэргэжлийн чиглэлийн онол, практикийн асуудлыг дэс дараатайгаар шийдвэрлэж “Баруун бүсийн тэргүүлэгч байгууллага” болох алсын хараа, эрхэм зорилгын дор нэгдэн үйл ажиллагаа явуулж байна.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дулааны эрчим хүч үйлдвэрлэх, хангах, түгээх, худалдах гэж тодорхойлж, байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд ТӨХК статустай байна.

Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь хувьцаанаас бүрдэх бөгөөд нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 13,640,526,161.23 ширхэг энгийн хувьцаа байна.

Компани нь 100 хувь төрийн өмчит хувьцаат компани хэлбэрээр үүсгэн байгуулагдсан бөгөөд хувьцаа эзэмшигчийн эрхийн 70 хувийг Эрчим хүчний яам, 30 хувийг төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар эзэмшиж байна.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хяналтын албаны санхүүгийн хяналтын дотоод нь тайлант онд хийх ажлын төлөвлөгөөг 1 чиглэлд нийт 11 ажил хийхээр батлуулж, үүнээс 10 ажлыг 100.0 хувь, 1 ажлыг 0 хувь, нийт 91.0 хувийн гүйцэтгэлтэй биелүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### ***Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар***

Ховд Дулааны станц ТӨХК нь Засгийн газрын 2017 оны 133 дугаар тогтоолыг үндэслэн бие даасан төрийн өмчит хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлэн өөрчлөн зохион байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн удирдлагыг ТУЗ-ийн хурлын тогтоолоор томилж байгаа нь Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 1.8 дах заалт “Компанийн гүйцэтгэх удирдлагыг сонгох өөрчлөх, түүний бүрэн эрхийг тогтоох”, ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор томилж байгаа нь Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1.7 дах

заалт “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох” гэсэн заалтуудтай нийцэж байна.

Ховд Дулааны станц ТӨХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллыг сард 0.5сая төгрөгөөр тогтоосон нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д “...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэсэн заалтай нийцэж байна

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ховд Дулааны станц ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусгавар болсон 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

#### ***Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар***

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцээгүй тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохироогүй байна.

Компанийн гүйцэтгэх захирлын 2018 оны 12 дугаар сарын 29 өдрийн А/106 дугаар тушаалаар баталж , мөрдөж буй НБББББ-нь үйл ажиллагааны онцлогт тохирсон эсэхэд горим сорил хэрэгжүүлэхэд борлуулсан бүтээгдэхүүний өртөг, бараа материалын тусгайлсан бодлого нь тухайн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон бүртгэлийн горим, журам байхгүй зөвхөн онолын мэдээллийг багтаасан агууламжтай байгаа тул шинэчлэн батлах шаардлагатай байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Ховд Дулааны станц ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 419.0 сая төгрөгөөр буюу 32 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
----------	----------------	-----------------	----------

Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	2,532	14,626	(12,093)
Авлага	731,181	594,433	136,747
Бараа материал	920,093	866,663	53,430
Урьдчилж төлсөн зардал	-	21,345	(21,345)
Үндсэн хөрөнгө	11,049,312	11,625,131	(575,818)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>12,703,118</b>	<b>13,122,197</b>	<b>(419,079)</b>
Өр төлбөр	1,097,808	1,116,800	(18,992)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	11,605,310	12,005,398	(400,087)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>12,703,118</b>	<b>13,122,197</b>	<b>(419,079)</b>

Касс дахь бэлэн мөнгө 0.4 сая, банк дахь харилцах дансанд 14.1 сая нийт 14.6 сая төгрөг байна.

Тайлант онд үндсэн үйл ажиллагааны хүрээнд үүссэн айл өрхийн дулааны авлага 115.1 сая, төсөвт байгууллагаас авах дулааны авлага 40.7 сая, ААНБ авах дулааны авлага 364.9 сая, НӨАТ авлага 21.8 сая, бусад ААНБ, хувь хүмүүсээс авах бусад тооцооны авлага 51.9 сая төгрөгийн авлагууд тайлант оны авлагын өөрчлөлтөд нөлөөлсөн байна. Авлагын үлдэгдэлд хугацаандаа байгаа 423.0 сая төгрөгийн, хугацаа хэтэрсэн 171.2 сая төгрөгийн авлага байна. НБББББ-т тодорхойлсноор найдваргүй авлагыг нөөцийн аргаар тооцдог бөгөөд тайлант онд найдваргүй авлагын нөөц байгуулаагүй байна. Тайлант онд үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаанд 20.0 сая, БМ бэлтгэх урьдчилгаанд 1.3 сая нийт 21.3 сая төгрөгийн урьдчилгаа шилжүүлсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 866.6 сая төгрөг болж 53.4 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд сэлбэг хэрэгслийг урсгал болон их засварт зарцуулснаас шалтгаалжээ. Тайлант онд худалдан авалтаар 883.1 сая төгрөгийн бараа материалаар БМ данс нэмэгдсэн байна. Бараа материалын дансны үлдэгдэлд 6.0 сая төгрөгийн үнийн дүнтэй 2 тн галын цемент, 25.5 сая төгрөгийн үнэтэй Экономайзор хоолой, 23.3 сая төгрөгийн үнэтэй экран хоолой зэрэг 54.8 сая төгрөгийн бараа материалд хөдөлгөөн ороогүй байна. Энэ нь өмнөх онуудад бэлтгэсэн аваарын нөөцтэй холбоотой байна. Эдгээр бараа материал ашиглагдахгүй удсанаар хуучрах, эвдэрч гэмтэх, үнэ цэний бууралтад орох магадлал өндөр байна. Оны эцэст 11.9 сая төгрөгийн нүүрсний худалдан авалт хийж, нөөц үүсгэсэн байна.

Үндсэн хөрөнгө худалдан авсан 780.9 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд ДҮТ ТӨХХК-д богино хугацаат зээлийн үлдэгдэл өглөг 80.0 сая, Сангийн яам ногдол ашгийн өглөг 60.0 сая, нүүрс тээврийн хөлс 112.0 сая, НӨАТ өглөг 131.4 сая, ХХОАТ-ын өглөг 69.5 сая, ААНБ болон бусад өглөг 663.9 сая нийт 1116.8 сая төгрөгийн өр төлбөр байна.

Шалгагдагч компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт зардлыг эдийн засгийн үр ашгийн бууралт нь хөрөнгийг багасгах буюу өр төлбөрийг нэмэгдүүлж

байгаа бөгөөд хэмжиж болохуйц байвал хүлээн зөвшөөрнө, төлсөн, эсвэл төлөхөөр хүлээгдэж байгаа мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн нэрлэсэн үнээр хэмжинэ гэж заасан байна.

Зардал өмнөх онтой харьцуулахад 854.2 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь боловсруулсан цахилгаан эрчим хүчний хэмжээ өмнөх онтой харьцуулахад хувиар, үйлдвэрлэсэн дулааны эрчим хүчний хэмжээ 13.3 хувиар өссөнтэй холбоотойгоор зарцуулсан түлш, материалын зардал, цалингийн зардал, үйлдвэрийн ашиглалтын зардал нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөгт цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэхтэй холбоотой шууд материалын зардал буюу зарцуулсан түлш, түүхий эд материалын зардал, шууд хөдөлмөрийн зардал болох цалингийн зардал болон ашиглалтын зардал, элэгдлийн зардал, зээлийн хүүгийн зардал, хөдөлмөрийн аюулгүй байдлын зардал, зохицуулалтын үйлчилгээний зардал зэрэг зардлуудыг хамруулсан

### **3.5. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Ховд дулааны станц ТӨХК-ийн гүйцэтгэх захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, дээд шатны байгууллагаар батлуулж, биелэлтийг ханган ажиллах үүрэгтэй.

Эрчим хүчний сайдын 2022 оны А/135 дугаар тушаалаар Ховд дулааны станц ТӨХК-ийн 2022 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна.

Тайлант оны нийт орлогыг 3982.4 сая төгрөгөөр, нийт зардлыг 4936.2 сая төгрөгөөр, 953.9 сая төгрөгийн алдагдал байхаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 495.9 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 17 дугаар тогтоолоор орлогыг хэвээр нь баталж, зардлыг 5078.1 сая төгрөгөөр, алдагдлыг 1095.7 сая төгрөгөөр өсгөж тодотгосон байна

Гүйцэтгэлээр 4712.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 4723.9 сая төгрөгийн зардал гарган, 11.7 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 3982.4 сая төгрөг болж төлөвлөснөөс 4712.2 сая төгрөг буюу 18.3 хувиар давсан байна. Үүнд ДЭХ-ний орлого 4015.3 сая, төгрөгөөр өссөн зэрэг нь голлон нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 4723.9 сая төгрөг болж, төлөвлөснөөс 354.2 сая төгрөг буюу 7.0 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 3 нэр төрлийн 14 ажилд өөрийн эх үүсвэрээс 821.7 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд цэвэр ашиг 11.7 сая төгрөг болж, төлөвлөснөөс 1084.0 сая төгрөгөөр дутуу байгаа нь үйл ажиллагааны бус орлого, татаас санхүүжилтийн орлого нөлөөлсөн байна.

Эзэмшигчийн өмчийн дүн 419.0 сая төгрөгөөр өсөж 13122.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүнд :

- Төрийн өмчийн дүн 1640.5 сая төгрөг,
- Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл 1156.9 сая төгрөг,
- Хуримтлагдсан алдагдал өмнөх үеийн 3487.5 сая төгрөг,
- Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг 695.4 сая төгрөг,
- Тайлант үеийн алдагдал 11.78 сая төгрөгийн өөрчлөлтүүд нөлөөлж байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Ховд дулааны станцын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Төрийн аудитын газрын аудитор Д.Балжинням гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Ховд дулааны станцын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2023 оны 02 дугаар сарын 09-ны өдрийн 38 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр борлуулалтын орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэв

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлангийн борлуулалтын орлогын 4119,8 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 82.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн байгууллага 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2 - 15.1.7 дахь заалтуудад заасан хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 172 мэдээллээс хугацаа болоогүй 2, хугацаандаа оруулсан 170 мэдээлэл, хугацаа хоцроосон мэдээлэл байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

##### **Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшин :**

1. Зорилтот түвшний төлөвлөгөөг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулан үзэхэд шугамын алдагдал 19.2 % өссөн, борлуулалтын нэг төгрөгт ногдох зардал 1.28 төг өссөн, авлага төлөвлөгөөнөөс 404.7 сая төгрөгөөр өссөн, өглөг 337.8 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байгаа нь хүрсэн түвшин болон зорилтот түвшний үзүүлэлтүүдийг бууруулан ажилласан байна.

Энэ нь компани удирдлага ТУЗ-ийн 2022 он 17 дугаар тогтоолоор баталсан компани эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшингийн төлөвлөгөөний гол үзүүлэлтүүдийн хүрсэн түвшнийг бууруулахгүй байх чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллах гэрээний үүргийн биелэлт хангагдаагүй байна.

##### **2. Татвар төлбөр хураамжтай холбоотой асуудал :**

Компани нь Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч бус 53 бэлтгэн нийлүүлэгчээс 263.3 сая төгрөгийн худалдан авалт хийсэн нь НӨАТ-ын буцаан авалтын хөнгөлөлт чөлөөлөлтөө эдлэх боломжгүй болгож, зардал өсөхөд хүргэсэн байна.

*Энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1 "Монгол Улсын нэтэг дэвсгэрт үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварыг төсөвт төлөх албан татвараас хасаж тооцно" гэсэн заалтыг зөрчиж, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна. Өгсөн зөвлөмж: Худалдан авалтыг хийхдээ НӨАТ төлөгч хуулийн этгээдийг сонгож, компанийн НӨАТ-ын буцаалтыг нэмэгдүүлэх.*

##### **3. Авлагын данстай холбоотой асуудал :**

Тайлант оны санхүүгийн тайлангийн урьдчилж төлсөн зардал дансанд НӨАТ-ын хувь тэнцүүлэн хасах /авлага/ нэрээр 21.8 сая төгрөгийг бүртгэж тайлагнасан нь

*Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Цахилгаан, дулаан, хий, усан хангамж, шуудан, харилцаа холбооны болон бусад тогтмол үйлчилгээнд албан татвар ногдуулах хугацааг төлбөрийн баримт үйлдсэн буюу төлбөрийг хүлээн авсан өдрийн аль түрүүнд хийгдсэнээр нь тогтооно" гэж заасантай нийцээгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.*

##### **4. Батлагдсан бүтэц орон тоо, ажлын байрны шинжилгээ :**

Ховд Дулааны станц ТӨХК-ний ТУЗ-ийн тогтоолоор компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тоог 2022.06.13 өдрийн 15 дугаар тогтоолоор баталж дотоод хяналтын албыг 5 орон тоотойгоор батлуулсан байна. Тайлант онд дотоод хяналтын албаны дарга нь хөдөө мал маллах ажилтай байгаа тул 3 сарын чөлөө авсан боловч чөлөөний хугацаа дуусаж 2022.12.31 дуустал ажилдаа эргэн ороогүй байна.

*Энэ нь компани удирдлага ажлын байранд шинжилгээ хийж, ажлын байрны давхардлыг арилгах, хэрэгцээ шаардлагад үндэслэн бүтэц орон тооны судалгаа хийгээгүйгээс цалин хөлс дансанд үргүй зардал санхүүжүүлсэн зөрчил дутагдал нь чиг үүрэгтэй ижил эрх, үүрэг бүхий өөр нэршилтэй албан тушаалын орон тоо бий болгож тогтоолын хэрэгжилт хангагдахгүй байна.*

## 5. Харилцагчтай байгуулсан гэрээний хэрэгжилт, баримтын бүрдэл

Тайлант онд орон сууцны барилга барих 15 аж ахуйн нэгж байгууллагатай дулааны эрчим хүчээр хангах гэрээ байгуулан төлбөр тооцоог аж ахуйн нэгжийн тарифаар тооцохоор баталгаажуулсан байна. Борлуулалтын орлогын тооцоог хянахад аж ахуйн нэгжийн барилга байгууламжийн улсын комисст хүлээлгэн өгсөн акт болон бусад баримт бичгийн бүрдэл дутуу байхад төлбөр тооцоог айл өрхийн тарифт шилжүүлж байгаа нь борлуулалтын орлого буурах эрсдэлийг дагуулж байна.

*Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 13.6- д. “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7 -д.”Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэнтэй нийцэхгүй байна.*

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тухайн байгууллагад зорилтот түвшинд удирдлагын шатахууны зардлыг хэтрүүлэн зарцуулсан, зорилтот түвшинд үйлдвэрлэлийн хэлтсийн ажилчдад олгох үр дүнгийн урамшуулалд зарцуулах зардлыг батлуулаагүй, батлагдаагүй орон тоонд ажил хавсран ажилласны нэмэгдэл олгосон, засгийн газрын 43 дугаар тогтоолын дагуу батлагдсан төсөвт зардлын 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаагүйтэй холбоотой зөрчлүүдэд албан шаардлага, зөвлөмж өгөгдсөнийг тайлант онд бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	3	13.440	3	13440	100
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>13440</b>	<b>3</b>	<b>13440</b>	<b>100</b>

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар аваарын нөөцийн бараа материалын бүрдүүлэлтийн журмын хэрэгж илт, улс орон нутгийн хөрөнгө оруулалтын үр дүн, тайлант онд ашиглалтад орох айл өрх, орон сууцтай холбоотой төлбөр тооцоог дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар байгууллагын ирүүлсэн санхүүгийн тайланд залруулга хийх алдаа<sup>1</sup> илрээгүй болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 185.6 сая төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 185.6 сая төгрөгийн алдаа зөрчилд дахин давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгөгдлөө.

### 5.1 Залруулсан алдаа

Аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй

### 5.2. Зөвлөмж

#### 1. Авлага, өр төлбөрийн тооцооны данстай холбоотой асуудал

**Илрүүлэлт 1** Өр төлбөрийн дэлгэрэнгүй бүртгэлийг тооцоо нийлсэн акттай тулган шалгахад тайлант оны ажил гүйгээ, гэрээ хэлцлийн хүрээнд бий болсон бусдаас авах авлагын төлбөр тооцоог харилцагч байгууллага бүрээр тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 27.5 сая төгрөгийн зөрчил дутагдал илэрлээ.

*Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдээдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг хэрэгжүүлээгүй, оршин байх, эрх үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх зэрэг батламж мэдээдлүүдийг хангахгүй байна.*

**Өгсөн зөвлөмж:** Ажил гүйгээ, гэрээ хэлцлийн хүрээнд бий болсон бусдаас авах авлагын төлбөр тооцоог тооцоо нийлсэн актаар баталгаажуулж байх.

#### 2. НБББББ нь байгууллагын үйл ажиллагааны онцлогт нийцсэн эсэх

**Илрүүлэлт 2.**Компанийн гүйцэтгэх захирлын 2018 оны 12 дугаар сарын 29 өдрийн А/106 дугаар тушаалаар баталж, мөрдөж буй НБББББ-нь үйл ажиллагааны онцлогт тохирсон эсэхэд горим сорил хэрэгжүүлэхэд борлуулсан бүтээгдэхүүний өртөг, бараа материалын тусгайлсан бодлого нь тухайн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон бүртгэлийн горим, журам байхгүй зөвхөн онолын мэдээллийг багтаасан агууламжтай байгаа нь шаардлагад нийцэхгүй зөрчил дутагдал илэрлээ.

*Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана"; 20.2.2-т "аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах" гэж заасныг хэрэгжүүлээгүй, тайлант хугацааны ажил гүйлгээний "ангилал" батламж мэдээдлийг хангахгүй байна.*

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**Өгсөн зөвлөмж:** Байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байх, санхүү бүртгэл холбоотой гарсан хууль эрх зүй, стандартын өөрчлөлтүүдийг цаг тухай бүрд нь өөрчлөлтүүдийг тусгаж байх.

### 3. Гэрээ хэлцлийн хэрэгжилт

**Илрүүлэлт 3.** Өмнө онуудад төлбөр тооцооны өртэй аж ахуйн нэгжүүдэд шинээр халаалт холбох зөвшөөрөл олгож тайлант онд дахин төлбөр тооцооны өр үүсгэн ажиллаж байгаа зөрчил дутагдал илэрлээ.

Энэ компанийн гүйцэтгэх захирал нь аж ахуйн нэгж байгууллагатай дулааны эрчим хүчээр хангах гэрээ байгуулж, гэрээний 4.8-д " дулааны төлбөрөө дараалан 2 сар төлөөгүй тохиолдолд хэрэглэгчийн халаалт, халуун усны шугамыг тасалж гарсан зардлыг хэрэглэгчээс гаргуулна", 4.7-д дулааны төлбөрөө хугацаанд нь төлөөгүй хоног тутамд төлөөгүй үнийн дүнгийн 0.5%-иар алданги тооцно" гэснийг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Аж ахуйн нэгж байгууллагатай дулааны эрчим хүчээр хангах гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтийг ханган ажиллах

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл / сая.төгрөг /

Зөрчлийн товч утга	Үүнээс							
	Нийт алдаа		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
өмнө онуудад төлбөр тооцооны өртэй аж ахуйн нэгжүүдэд шинээр халаалт холбох зөвшөөрөл олгож тайлант онд дахин төлбөр тооцооны өр үүсгэн ажилласан	1	158.1					1	158.1
Тайлант оны ажил гүйгээ, гэрээ хэлцлийн хүрээнд бий болсон бусдаас авах авлагын төлбөр тооцооны өглөгийг харилцагч байгууллага бүрээр тооцоо нийлсэн акт үйлдээгүй	1	27.5					1	27.5
НБББББ-нь үйл ажиллагааны онцлогт тохирсон эсэхэд горим сорил хэрэгжүүлэхэд борлуулсан бүтээгдэхүүний өртөг, бараа материалын тусгайлсан бодлого нь тухайн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон бүртгэлийн горим, журам байхгүй зөвхөн онолын мэдээллийг багтаасан агууламжтай байна.	1	0,0					1	0,0
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>185.6</b>					<b>3</b>	<b>185.6</b>

### АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

**ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:**

**Х.БОЛДБААТАР**

**АУДИТЫН МЕНЕЖЕР:**

**А.ЦЭЦЭГСҮРЭН**

### ТАЙЛАНГ БИЧСЭН:

**АУДИТОР:**

**Д.БАЛЖИННЯМ**

